



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Халамжийн сан /Орон нутгийн төсөв/ -ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/2/СТА/ОНТС

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2021 он

Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор: М.Алтантуяа

Утас: 99061861 Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт/эх хувь/ .....	4
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	6
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
<b>2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....</b>	<b>6</b>
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3.Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл .....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал.....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	12

## Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		
51	Засгийн газрын хувь оролцоо		
512	Хуримтлагдсан үр дүн		
51210	Өмнөх үеийн үр дүн	(95,065,730.00)	
51220	Тайлант үеийн үр дүн	95,065,730.00	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		

### 2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	246,880,576.16	151,671,831.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	772,846.16	219,831.15
120	Нийтлэг татварын бус орлого	772,846.16	219,831.15
120002	Хүүгийн орлого	360,346.16	219,831.15
120009	Бусад орлого	412,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	246,107,730.00	151,452,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	246,107,730.00	151,452,000.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	246,107,730.00	151,452,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	151,814,846.16	151,671,831.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,814,846.16	151,671,831.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,814,846.16	151,671,831.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,775,000.00	150,772,500.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	150,775,000.00	150,772,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,039,846.16	899,331.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,039,846.16	899,331.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	95,065,730.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	95,065,730.00	-



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Б А Я Н Х О Н Г О Р А Й М Г И Й Н Х Э Д Э Л М Э Р  
Х А Л А М Ж И Й Н Ү Й Л Ч И Л Г Э Э Н И Й Г А З Р Ы Н  
Д А Р Г А Д . А М А Р С А Н А А Т А Н А А

2021.01.28 № 2/03

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Халамжийн сан /орон нутгийн төсөв/-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Халамжийн сан /орон нутгийн төсөв/-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

2021 A4 TOOT

• 005020826

Аудитаар Баянхонгор аймгийн Халамжийн сан /орон нутгийн төсөв/-ийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



### 2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>246,880,576.16</u></b>	<b><u>151,671,831.15</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>772,846.16</b>	<b>219,831.15</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	772,846.16	219,831.15
120002	Хүүгийн орлого	360,346.16	219,831.15
120009	Бусад орлого	412,500.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>246,107,730.00</b>	<b>151,452,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	246,107,730.00	151,452,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	246,107,730.00	151,452,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>246,880,576.16</u></b>	<b><u>151,671,831.15</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>246,880,576.16</b>	<b>151,671,831.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>94,655,730.00</b>	<b>-</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	94,655,730.00	-
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	94,655,730.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>152,224,846.16</b>	<b>151,671,831.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	151,185,000.00	150,772,500.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	151,185,000.00	150,772,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,039,846.16	899,331.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,039,846.16	899,331.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-</u></b>	<b><u>-</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл			-95,065,730.00	-95,065,730.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-95,065,730.00	-95,065,730.00
C07	Тайлант үеийн үр дүн			95,065,730.00	95,065,730.00
C08	2019 оны 21-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D09	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

## 2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,452,000.00	150,772,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,452,000.00	150,772,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,452,000.00	150,772,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,452,000.00	150,772,500.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	151,452,000.00	150,772,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	151,452,000.00	150,772,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	151,452,000.00	150,772,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	151,452,000.00	150,772,500.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Халамжийн сан орон нутгийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга С.Амарсанаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээллээр талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021.01.21-ноос 2021.01.26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.01.28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцан хэрэгжүүлэв.

Халамжийн сан орон нутгийн төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэхээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.01.08-ны өдрийн 908 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Халамжийн сан орон нутгийн төсөв нь “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэхэд халамж, асрамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог ханган хамтран ажиллах, хуваарилагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зөв зарцуулах, анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудыг арга зүйн удирдлагаар хангах ажилд манлайлагч байна.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй нийгмийн хамгааллын тухай хууль, болон бусад журам, дүрэм, тогтоомжийн хэрэгжилтийг хангахад гүйцэтгэлийн удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийг цаг тухайд нь чирэгдэлгүй олгох ажлыг үр дүнтэй зохион байгуулах Нийгмийн халамжийн сангийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төслийг бодитой, үнэн зөв боловсруулах, холбогдох газруудад хүргүүлэн батлуулах.

- Батлагдсан төсвийн зарцуулалтыг улирал, хагас бүтэн жилээр иргэдэд болон хэлтсийн удирдлага хамт олонд нээлттэй тайлагнаж ажиллах
- Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах чиглэлээр санал санаачилга гарган, анхан шатанд ажиллаж байгаа ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах
- Нийгмийн халамжийн сангийн санхүүжилтийг цаг хугацаанд нь авах, бодитой, үнэн зөв хуваарилах, гэрээт банк уруу шилжүүлэх ажлыг чанартай зохион байгуулах
- Газрын олголт хариуцсан мэргэжилтэнтэй хамтран олголтын файлыг банканд хүргүүлэхдээ сард 2-оос доошгүй удаа татах, хүртээх болон олголтын файлыг тулгаж хаалт хийх.
- Хуульд заасан тусламж хөнгөлөлтийн мөнгийг нэхэмжлэлийн дагуу холбогдох байгууллагад шилжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Халамжийн сан орон нутгийн төсөв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Халамжийн сан орон нутгийн төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 151671.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 3033.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

### **3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд**

Халамжийн сан орон нутгийн төсвийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд жилийн эцэст үлдэгдэлгүй болно.

Нийт зардал өмнөх оноос 95208.7 мянган төгрөгөөр буюу 61,4 хувиар буурсан нь 2018 онд үүссэн 95065.7 мянган төгрөгийн халамжийн сангийн өглөгийг 2019 онд барагдуулсантай холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 197200.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 197200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийг 86 иргэнд 103200.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 1113 иргэнд 94000.0 мянган төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлэхээр Баянхонгор аймгийн СТСХэлтэст хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс өмнөх оны батлагдсан төсвөөр буюу 45748.0 мянган төгрөгөөр бууруулж 151420.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Халамжийн сан орон нутгийн төсвөөр 2 төрлийн халамжийн үйлчилгээг санхүүжүүлэхээр 151452.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 151452.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 151452.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, арилжааны банкны харилцахын хүүгийн орлогод 219.8 мянган төгрөг хүлээн авч, халамжийн тэтгэмжид 150772.5 мянган төгрөгийг зарцуулж 889.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тухайн санд нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 62 мэдээллээс хугацаандаа оруулсан 55 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 7500.0 мянган төгрөгийн 3 мэдээлэл байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуул аагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	8	8	3	3	0	2
2	Хагас жил	2	2	2			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	1	12	12			
5	Тухай бүр	3	36	34	2		
6	Нийт	15	62	55	5	0	2

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил арилгах зөвлөмж өгөөгүй болно.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7500.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7500.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 7500.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу холбогдох мэдээллийн [shilendans@gov.mn](mailto:shilendans@gov.mn) сайтад хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлсэн эсэхийг шалгахад нийт 62 мэдээлэл байршуулахаас 55 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан ба 7500.0 мянган төгрөгийн 5 мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроож байршуулсан байна.

3.2 Эрсдэл: Шилэн дансны мэдээллийн үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулаагүй байх

3.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>1</sup>, 7.1.3<sup>2</sup> заалтын дагуу шилэн дансанд мөн хуулийн 6 дугаарт заасан холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Бэлтгэсэн:  
АХЛАХ АУДИТОР

Анхан шатанд хянасан:  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

Хоёр дахь шатанд хянасан:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.АЛТАНТУЯА  
Огноо: 2021.01.28

А.ЦЭЭНЯМ  
Огноо: 2021.01.28

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.01.28

<sup>1</sup> Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ:

<sup>2</sup> тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан.